



БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 06 дугаар сарын 21 – ны өдөр

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН АЖЛЫН ДААЛГАВАР

1. ЗОРИЛГО

Энэ техникийн тодорхойлолтод Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа албадуудын жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, шаардлага хангасан даатгалын компани сонгон шалгаруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эрсдлийг бууруулах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Даатгалын тухай Монгол улсын хууль, Жолоочийн даатгалын тухай Монгол улсын хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 212 дугаар тогтоолын хавсралт

3. ДААТГУУЛАГЧ

- Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба, Шатахуун хангалтын алба, Буянт-Ухаа ОУНБ-ын галын хэсэг, Аэродром, гэрэл суултын алба зэрэг байгууллагуудын нийтийн тээврийн жолооч, агаарын хөлгийн газрын үйлчилгээний жолооч-операторчин, аэродромын үйлчилгээний жолооч-механизмчин, инженер, техникч, мэргэжилтэн нарыг хамруулах
- ГТҮШХА-118, ШХА-15, Буянт-Ухаа ОУНБ-ын галын-4, АГСА-4 ээлжийн инженер нийт-141 инженер, мэргэжилтэн, техникч, жолооч нарыг даатгуулах

4. ДААТГАГЧ

- Даатгалын хууль, журмын дагуу нөхөн төлбөр барагдуулах чадвартай байх
- Нөхөн төлбөрийг үнэлгээний компанийн гаргасан дүнгээр бүрэн олгох
- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон даатгалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх
- Даатгалд хамрагдсан жолооч нарын нэрсэд өөрчлөлт орох /ажлаас чөлөөлөгдөх, өндөр насны тэтгэвэрт гарах, нас барах, өөр байгууллагад шилжин ажиллах/ тохиолдол бүрт даатгуулагчаас хүргүүлсэн хүсэлтийг үндэслэн даатгалд хамрагдсан жолоочийн тоонд багтаан гэрээний хавсралтад тухай бүр нь өөрчлөлт оруулж, шинэ жолооч, ажилтанг жагсаалтад нэмж даатгалд хамруулах

5. ДААТГАЛЫН НИЙТ ХУРААМЖ

Төсөвт өртөг-30,000,000төг

6. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ


Жолоочийн даатгалын Монгол улсын хуулийн 9 дугаар зүйлийн 9.2-д заасны дагуу үнэлгээ хийх

7. ДААТГАЛЫН ЭРСДЛҮҮД

№	Даатгах эрсдлүүд	Хамгаалалт /хувь/
1	Жолооч нь автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үед болон Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа төв болон орон нутгийн нисэх буудлуудын хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэж байхдаа бусдын эд хөрөнгөд учруулсан хохирол	100
2	Жолооч нь автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үед болон Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа төв болон орон нутгийн нисэх буудлуудын хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэж байхдаа бусдын эрүүл мэндэд учруулсан хохирол	100
3	Жолооч нь автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үед болон Иргэний нисэхийн ерөнхий газрын төв болон орон нутгийн нисэх буудлуудын хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэж байхдаа бусдын амь насанд учруулсан хохирол	100

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа
Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын
албаны Ерөнхий инженер;



Б.Гантулга

Иргэний нисэхийн үндэсний төвийн, Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн;



Э.Уянга

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”
Төрийн бус байгууллагын тэргүүн,
(тохиролцсоноор);



Б.Мэндсайхан